



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2016 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 0/40

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар бүлгийн 2.9, 4 дүгээр бүлгийн 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, стандартын шаардлагыг хангуулах, гадна фасад, орчны тохижилт, гэрэлтүүлэг, хаягжилт, угаалга цэвэрлэгээ хийлгэх, хотын өнгө үзэмжийг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх зорилгоор хийгдэх аттестатчилалын шалгалтын хүрээнд төвийн 6 дүүрэгт 2016 оны 05 дугаар сарын 17, 18, 19-ний өдрүүдэд сургалт зохион байгуулахыг Хүнс худалдаа, үйлчилгээний хэлтэс /О.Нарантуяа/ -т даалгасугай.

2. Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад аттестатчилалын сургалт зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Аттестатчиллын хүрээнд хийгдэх сургалтанд шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар баталж 3,691,800.00 төгрөг /гурван сая зургаан зуун ерэн нэгэн мянга найман зуу/ -ийг Бусад бараа үйлчилгээний зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

4. Сургалт явуулсан дүнг нэгтгэж Ерөнхий менежерт танилцуулж, зардлын тооцооны гүйцэтгэлийг гарган тайлагнахыг Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс /О.Нарантуяа/ -д үүрэг болгосугай.

ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР БӨГӨӨД
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Б.БАДРАЛ



**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ БОЛОН ТҮҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХУДАЛДАА, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРУУДАД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Нэг. Сургалтын зорилго:

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй согтууруулах ундаа худалдаалдаг болон түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагуудад Монгол Улсын "Архидан согтуурахтай тэмцэх тухай", "Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай", "Хүнсний тухай", "Эрүүл ахуйн тухай" хууль болон НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 63, 2012 оны 61, 2014 оны 07, 2015 оны 205 тоот тогтоол болон холбогдох стандартуудыг сурталчлан таниулахад оршино.

Хоёр. Сургалтын хамрах хүрээ:

Сургалтанд 2016 Аттестатчиллын шалгалтанд хамрагдах Баянзүрх, Хан-Уул, Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Багахангай дүүрэгт хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, /баар, кафе, ресторан/, бөөний болон жижиглэн худалдааны чиглэлээр 2014 оны 06 сараас хойшхи тусгай зөвшөөрөлтэй газрууд болон шинээр тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдах ажилтан, менежерүүд хамрагдана.

Гурав. Сургалт зохион байгуулах бүрэлдэхүүн:

- 3.1 Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс
- 3.2 Дүүргүүдийн Засаг даргын тамгын газрын Худалдаа, үйлчилгээний хэлтэс
- 3.3 Дүүргүүд дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс
- 3.4 Дүүргүүдийн Цагдаагийн хэлтэс

Дөрөв. Сургалт зохион байгуулах чиглэл:

- 4.1 Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс шалгалтын удирдамжийг танилцуулна.

4.2 Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Тохижилт хог хаягдлын удирдлагын хэлтсээс НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 63, 2012 оны 61 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх талаар мэдээлнэ.

4.3 Дүүргүүд дэх Мэргэжлийн хяналтын хэлтсээс “Хоолны газрын ангилал, зэрэглэл, үндсэн шаардлага MNS4946:2005” стандарт, “Худалдааны газар түүний үйлчилгээ MNS5021:2007” стандартуудыг таниулж сурталчилна.

4.4 Дүүргийн Цагдаагийн хэлтсээс “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийг хэрэгжүүлэх тухай мэдээлэл хийнэ.


Тав. Сургалт зохион байгуулах хуваарь:

Сургалтыг 2016 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс 05 дугаар сарын 19-ний өдрүүдэд зохион байгуулна.

№	Дүүрэг	Сургалт явуулах хугацаа, цаг	Хариуцах мэргэжилтэн
1	Баянзүрх дүүрэг	2016.05.17	Я.Бадмаа ЗАА
		11.00-13.00	Т.Сэргэлэн ЗАА Б.Халиунаа ЗДТГ
2	Сүхбаатар дүүрэг	2016.05.17	Я.Бадмаа ЗАА
		14.00-16.00	Т.Сэргэлэн ЗАА Н.Цогзолмаа ЗДТГ
3	Хан-Уул дүүрэг	2016.05.18	Я.Бадмаа ЗАА
		11.00-13.00	Т.Сэргэлэн ЗАА В.Бэгз ЗДТГ
4	Чингэлтэй дүүрэг	2016.05.18	Я.Бадмаа ЗАА
		14.00-16.00	Т.Сэргэлэн ЗАА Д.Булган ЗДТГ
5	Баянгол дүүрэг	2016.05.19	Я.Бадмаа ЗАА
		11.00-13.00	Т.Сэргэлэн ЗАА Э.Сансар ЗДТГ
6	Сонгинохайрхан дүүрэг	2016.05.19	Я.Бадмаа ЗАА
		14.00-16.00	Т.Сэргэлэн ЗАА Г.Ууганбаяр ЗДТГ

Зургаа. Сургалтын дүнг нэгтгэх, танилцуулах

Дүүргүүд сургалт зохион байгуулсан тухай илтгэх хуудсыг хэлтсийн даргаар баталгаажуулан 2016.05.23-ны дотор Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст албан бичгээр ирүүлнэ. Сургалтын дүн, мэдээг нэгтгэн Хотын Ерөнхий менежер болон хэлтсийн даргад танилцуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.



СУРГАЛТАНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ЖАГСААЛТ

№	Бүтээгдэхүүн	Тоо, хэмжээ	Нэгж үнэ /төгрөг/	Нийт дүн	Хянасан
1	Бичгийн цаас	12 боодол /6 дүүрэгт/	7650	91 800	
2	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын эмхтгэл	1800ш /6 дүүрэгт/	500	900 000	
3	Нийслэлийн худалдаа, үйлчилгээний нийтлэг журмын эмхтгэл	1800ш /6 дүүрэгт/	500	900 000	
4	Зөвлөмж зурагт хуудас	1800ш /6 дүүрэгт/	1000	1 800 000	
Нийт сургалтын зардал			3 691 800		